

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч буй шалтгаан
1	2	3	4	5	6
САЛБАР ЧИГЛЭЛ: 1					
1. Монгол Улсын хууль					
1.1		Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2023.07.07	<p>2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд сурталчлан таниулах, мэдээллээр хангах зорилгоор тус газрын сургалтын төлөвлөгөөнд тусгуулан сургалтыг шат дараалалтайгаар хийж ажилласан.</p> <p>Мөн тус газрын шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Эрдэнэчимэг, магадлагч эмч Ж.Өнөгэрэл, хяналтын байцаагч нар төлөвлөгөө гарган сургалтуудыг 7 хоногийн турш үргэлжилсэн зохион байгуулсан. /Сургалтын тайланд дэлгэрэнгүй тусгагдсан/</p>		
1.2		Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль 2023.07.07	<p>2024 онд шинээр хэрэгжиж эхэлж байгаа хуулийн хэрэгжилтийн хүрээнд Сүхбаатар дүүргийн сар бүр дунджаар 23797 тэтгэвэр авагчдад 20,1 тэрбум төгрөгийн тэтгэврийг хугацаанд нь олгож байна. Шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 1435 тэтгэвэр авагчдын материалыг шинэ хуулийн дагуу</p>		

			шалган хүлээн авах, ажилласан жил нэмэх болон дундаж цалин өөрчлөх 1981 тэтгэвэр авагчийн материалыг хүлээн авч өөрчлөлтийг оруулах, шинэ хуулийн тэтгэврийн тусгай зохицуулалтын дагуу 103 тэтгэвэр авагчид 20% нэмэгдэл олгох, хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэврийн 1285 тэтгэвэр авагчдын сунгалт хөдөлгөөн хийх зэргээр нийт 4804 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт өөрчлөлт хийсэн байна.		
1.3		Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль 2023.07.07	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 15556 даатгуулагчдад 25,8 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжид 10465 даатгуулагчдад 4,5 тэрбум төгрөг - Жирэмсэн амаржсаны тэтгэмжид 2223 даатгуулагчдад 9,7 тэрбум төгрөг - Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийг 644 даатгуулагчдад 1280,0 сая төгрөг - Ажилгүйдлийн тэтгэмжид 2224 даатгуулагчдад 10,3 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгосон байна. 		
1.4		Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай 2023.07.07	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас 322 даатгуулагчдад 20,0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж бодож олгосон байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - ХЧА тэтгэвэрт 143 хүнд 1,4 тэрбум төгрөг - ТА тэтгэвэрт 15 хүнд 123,3 сая төгрөг - ХЧТА тэтгэмжид 151 хүнд 457,4 сая төгрөг - ҮРМШӨ нөхөн сувиллын зардалд 13 хүнд 2,1 сая төгрөг 		
2. Засгийн газрын тогтоол					

2.1		<p>“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардал төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэх журам” батлах тухай 2023.11.29 №422</p>	<p>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагч эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардал төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэх журмын дагуу 2024 оны байдлаар 12 даатгуулагчийн 1,9 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж шилжүүлсэн бөгөөд дээрх журмыг бүрэн хэргэжүүлэн ажиллаж байна</p>		
2.2.		<p>“Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам” батлах тухай 2023.12.13 №438</p>	<p>“Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам” батлах тухай Засгийн газрын 2023 оны 438-р тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 15556 даатгуулагчдад 25,8 тэрбум төгрөгийн тэтгэмж олгож, нотлох баримт бичгийг журамд заасны дагуу бүрдүүлэн ажилласан.</p>		
2.3		<p>“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам” батлах тухай 2023.12.13 №439</p>	<p>“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам” батлах тухай Засгийн газрын 2023 оны 439-р тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 322 даатгуулагчдад 2,1 тэрбум төгрөгийн тэтгэмж олгож, нотлох баримт бичгийг журамд заасны дагуу бүрдүүлэн ажилласан.</p>		

2.4		<p>“Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм” батлах тухай 2023.12.13 №448</p>	<p>МУ-ын Засгийн газрын 2023 оны 448-р тогтоолоор батлагдсан дүрмийн хэрэгжилтийг бүрэн хангаж, ЭММЗ-ийн хурлыг тайлант оны 01.01-ний өдрөөс эхлэн иргэдийг байлцуулахгүйгээр, 100% бичиг баримтанд тулгуурлан хуралдаж, нийт 46 удаа хуралдаж, 1912 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлээд байна, үүнээс 1355 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, жагсаалтын шаардлагад нийцсэн 421 иргэнд өвчний явц, шинжилгээ, үзлэг, өвчтөнд илэрч буй зовиур өөрчлөлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож, биеийн байдал сайжирсан, эдгэрсэн, хяналтын хугацаа дууссан шалтгаанаар 133 иргэний хувь, хугацааг цуцлаад байна.</p> <p>Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинэчилсэн дүрэм, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхэд баримтлах өвчний шинэчилсэн жагсаалтыг өрхийн болон нарийн мэргэжлийн эмч нарт танилцуулах сургалтыг хийж, шинэчилсэн жагсаалтыг цаасаар болон цахимаар тарааж, мэдээллээр хангасан.</p>		
2.5		<p>“Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам” батлах тухай 2023.12.20 №450</p>	<p>“Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичиг, тэтгэвэр олгох журам” батлах тухай Засгийн газрын 2023 оны 450-р тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж, 2024 онд сард дунджаар 23797 даатгуулагчдад 20,1 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгож, нотлох баримт бичгийг журамд заасны дагуу бүрдүүлэн хувийн хэрэг үүсгэн ажилласан.</p>		
2.6		<p>“Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”, “Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн дүрэм” батлах тухай 2023.12.27</p>	<p>2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн дагуу тус газар нь нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, шимтгэлийн орлогыг бүрдүүлэх, улсын төсвөөс олгох</p>		

		№469	<p>хөрөнгө, нийгмийн даатгалын сангуудын зарлага, санхүүжилтийн талаар санхүүгийн мэдээллээр хангах, тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж өгөх зэргээр тус дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон баримтлан ажиллаж байна.</p> <p>“Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн дүрэм”-ийн дагуу тус газрын Нийгмийн даатгалын Улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төсвийн тухай хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэ дүрмийг удирдлага болгон ажиллаж байна.</p>		
2.7		“Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 1.5, 2.5 хувиар төлөх ажил мэргэжлийн жагсаалт, жагсаалтыг	<p>Энэхүү журмыг байцаагч, ажилтнуудад үүрэг даалгаврын хуудсаар танилцуулан мэргэжил арга зүйгээр ханган ажиллав. Эрсдэл бүхий ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөөс хамааралтайгаар ажил олгогчийн төлвөл зохих үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 1.5, 2.5 хувиар төлөх жагсаалтыг ажил олгогч байгууллагын захирал, нягтлан, хүний нөөц</p>		

		хэрэглэх журам"-ыг батлах тухай 2023.12.27 №471	хариуцсан мэргэжилтэнд зөвлөгөө өгч мэдээ мэдээллээр хангаж ажилласан.		
2.8		“Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хууль, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгоход 2024 онд итгэлцүүр тогтоох тухай 2024.01.10 №10	“Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хууль, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгоход 2024 онд итгэлцүүр тогтоох тухай Засгийн газрын 2024 оны 10-р тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж, ҮОМШӨ даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа алдсаны 143 тэтгэвэр авагч, цэргийн 249 тэтгэвэр авагчдын шинэ тэтгэврийн тогтоолт хийхэд итгэлцүүр ашигласан.		
3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал					
3.1		“Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт” батлах тухай 2023.12.15 №А/441, А/192	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинэчилсэн дүрэм, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхэд баримтлах өвчний шинэчилсэн жагсаалтыг өрхийн болон нарийн мэргэжлийн эмч нарт 2 удаа, танилцуулах сургалтыг хийж, шинэчилсэн жагсаалтыг цаасаар болон цахимаар тарааж, мэдээллээр ханган ажиллаж байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, анхан шатны эмч нарыг чадавхжуулах 1 өдрийн сургалтанд тус хэлтсийн дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 5 гишүүн, Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн 2 эмч, өрхийн 2 эмчийг оролцуулж,		

			шинээр баталсан жагсаалт болон гарын авлагыг танилцуулах сургалтанд оролцуулав.		
3.2		“Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар”, “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх аргачлал” батлах тухай 2024.03.06 №А/44, А/40	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар, аргачлалын дагуу маягтууд батлагдсан загвараар гарч байгаа бөгөөд гарын үсэг баталгаажилтын бүрдэлийг хянан архивын нэгж болгон хадгалж байна.		
4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал					
4.1		“Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх” журам батлах тухай 2023.12.25 №199	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах нөхөн төлүүлэх журмыг байцаагч ажилтнуудад үүрэг даалгаврын хуудсаар танилцуулан мэргэжил арга зүйгээр ханган ажиллав. 97 ажил олгогч байгууллагын 489 даатгуулагчийн 1,821.4 сая төгрөгийн цалингийн санд ногдох 247.3 сая төгрөгний шимтгэл, 86.8 сая төгрөгний алдангийн хамт ний 334.1 сая төгрөгний акт тавигдсан. Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн дагуу хялбаршуулсан журмаар 46 аж ахуй нэгж байгууллагад 10.17 зүйлийн 10.17.2, 10.17.4, 10.17.8, 10.17.9 заалтаар нийт 44.0 сая төгрөгийн шийтгэврийн хуудас бичигдсэн.		
4.2		Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад баримтлах журам, Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай	Батлагдсан загвар маягыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр шинээр сайн дурын 1932 даатгуулагч, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх 263, малчин 6, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй эх эсхүл /эцэг/ 451 даатгуулагчийг хамруулан ажилласан байна.		

		<p>гэрээ, гурав хүртэлх насны хүүхдээ асарч буй эхийн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ, малчин, туслах малчны нийгмийн даатгалын сайн дураар даатгуулсан тухай гэрээ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/-ийн нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээний загвар батлах тухай 2023.12.25 №200</p>	<p>Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсээс хөгжлийн бэрхшээлтэй, асаргаатай, хүүхдээ асарч байгаа эцэг эхийн 938 иргэний мэдээллийг авч хамралт нэмэгдүүлэх зорилгоор даатгуулагчид зөвлөгөө өгч ажилласан.</p>		
4.3		<p>“Итгэлцүүр хэрэглэх журам” батлах тухай 2023.12.25 A/202</p>	<p>2024 онд сард дунджаар 23797 тэтгэвэр авагчдад 20,1 тэрбум төгрөгийн тэтгэврийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас тэтгэвэр бодох цалинг шууд татаж журмын дагуу итгэлцүүрээр өсгөн тогтоон олгож байна.</p>		
4.4		<p>“Газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, жагсаалтыг хэрэглэх журам” батлах тухай 2023.12.28 A/221</p>	<p>“Газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, жагсаалтыг хэрэглэх журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж, 2024 онд 32 нийт тэтгэвэр авагчдийн тэтгэврийг газрын дор, хортой, халуун, хүнд нөхцөлөөр тогтоон олгож байна. Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлөөр хүнд нөхцөлөөр 3, хортой нөхцөлөөр 1 даатгуулагчийн хөдөлмөрийн нөхцөлийг тогтоолгосон байна.</p>		
4.5		<p>“Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан</p>		

		шалгалтын журам” батлах тухай 2024.03.01. №А/40	“Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн шалгалтын журам”-д заасны дагуу болзол шалгуур хангаж байгаа 17 ажилтан, албан хаагч шалгалтад орсноос Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн шалгалтад 5 ажилтан, албан хаагч хангалтгүй үнэлгээ авсан бол 12 албан хаагч нь амжилттай өгч Нийгмийн даатгалын Улсын байцаагч шинээр болон баталгаажуулсан болно.		
4.6		“Газрын доор хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2024.04.23 №А/87	“Газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт, жагсаалтыг хэрэглэх журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж, 2024 онд 32 нийт тэтгэвэр авагчдийн тэтгэврийг газрын дор, хортой, халуун, хүнд нөхцөлөөр тогтоон олгож байна. Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлөөр хүнд нөхцөлөөр 3, хортой нөхцөлөөр 1 даатгуулагчийн хөдөлмөрийн нөхцөлийг тогтоолгосон байна.		
4.7		“Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хадгалах, ашиглах, мэдээлэлд хяналт тавих, нууцлал, аюулгүй байдлыг хангах журам”, “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хянах, хадгалах, хамгаалах журам” батлах тухай 2024.05.31 №А/113	2024 оны жилийн байдлаар 9364 аж ахуйн нэгж байгууллагын даатгуулагчдын регистрийн дугаарыг улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулган шалгаж ажилласан. Даатгуулагчийн үндсэн мэдээлэл, төрөл, ажил мэргэжлийн ангилал, кодыг тухай бүр шалган ажиллаж байна. Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгээгүй байна. Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системийн нэвтрэлттэй холбоотой программ хангамжуудын эрхийн тохиргоог байцаагч, нэгж болгоноор үүсгэн шинэ системд ажиллах боломжийг бүрдүүлсэн. Программ хангамж ашиглалт, аюулгүй байдлыг хангаж байцаагч, нэгж болгонд нууц үг, нэвтрэх нэр үүсгэсэн. МТТ-с зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичиг, ирүүлсэн заавар зөвлөмжийн дагуу байцаагч		

			<p>ажилтнуудад мэдээлэн таниулж шаардлагагай мэдээ мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>Шинэ системийн сургалтад тухай бүр хамрагдан нийгмийн даатгалын байгууллагын Мэдээлэл технологийн ажилтнуудын цахим мэдээлэл солилцох хуудсаар бүртгэл үүсэхгүй, алдаа заах, систем нэвтрүүлэгчээс зайлшгүй засварлах, хөгжүүлэх шаардлагатай санал болон алдааны заалтыг тухай бүр хүргүүлэн хамтран ажиллаж байна.</p>		
5. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар					
5.1		<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай №1</p>	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгавар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Төлөвлөгөө батлах тухай” А/138 дугаар тушаалын нийт 14 үүргийн биелэлтийг нийгмийн даатгалын байгууллагын дотоод сүлжээний Захиргаа удирдлагын газрын албан даалгаврын биелэлт хэсэгт тухай бүр байршуулан ажилласан.</p>		
6. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал					
6.1		<p>“Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журам” батлах тухай 2023.10.24 A/139</p>	<p>2024 онд тэтгэвэр тогтоолгох үндэсний сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журмын дагуу сард дунджаар 23797 тэтгэвэр авагчдад 20,1 тэрбум төгрөгийн тэтгэврийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангаас тэтгэвэр бодох цалинг итгэлцүүрээр өсгөн тогтоон олгож байна.</p>		
6.2		<p>“Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэх, хөтлөх, шилжүүлэх</p>	<p>Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газарт шинээр бүртгүүлэх хүсэлт өгсөн 793 ажил олгогч байгууллагыг батлагдсан журмын дагуу SICOS программд бүртгэж ажил олгогчийн дугаарыг үүсгэн, нэвтрэх эрхийн бүртгэлийг хийж ажилласан.</p>		

		журам” батлах тухай 2023.12.27 A/190			
6.3		“Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим болон цаасан)”, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт” (цахим болон цаасан), “Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим болон цаасан), “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн өргөдлийн маягт” батлах тухай 2023.10.24 A/139	“Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”, “Ажилгүйдлийн тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим болон цаасан)”, “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах өргөдлийн маягт” (цахим болон цаасан), “Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах өргөдлийн маягт (цахим болон цаасан), “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн өргөдлийн маягт” батлах тухай журамд заасны дагуу шинэчлэгдсэн маягтуудыг өдөр тутмын ажилдаа хэрэглэж хэвшсэн байна.		
6.4		Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарь батлах тухай 2024.01.04 №A/02	Нийгмийн даатгалын сангийн 697.7 тэрбум төгрөгийн орлого, 271.1 тэрбум төгрөгийн зардлын батлагдсан төсвийг төсвийг зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. 2024 оны жилийн 697,7 тэрбум төгрөгийн төлөвлөгөөнөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 697,7 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулна гэж тооцон 271,1 тэрбум төгрөгийн зарлагын төсвөөс 270,0 тэрбум		

			<p>төгрөгийн гүйцэтгэл, төсвийг зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэлд хяналт тавин төсвийн сахилга батыг ханган ажилласан. 2024 оны жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр тэтгэврийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт 2200,0 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 110,0 сая төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид 1250,0 сая төгрөг, ҮОМШӨ даатаглын сангийн тэтгэмжид 155,0 сая төгрөг цэргийн тэтгэвэрт 120,0 сая төгрөг тус тус зардал төсвийн хуваариас хэтрэхээр тул тооцооллыг хийн НДЕГ-т төсвийн тодотгол хийлгүүлэх саналаа 4 удаа хүргүүлж 5 удаа тодотгол хийгдсэн.</p>		
6.5		<p>Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай 2024.04.02 №А/43</p>	<p>Энэ туушаалаар баталсандаатгуулагчийн төрлийн “08012”, “20012”, “28012”, “29012”, “30012”, “25022”, “25032” кодыг байцаагч ажилтнуудад үүрэг даалгаврын хуудсаар танилцуулан мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.</p>		
6.6		<p>“Магадлагч эмчийн дүрэм”-ийг шинэчлэн батлах тухай 2024.04.16 А/54</p>	<p>Шинэчлэн батлагдсан магадлагч эмчийн дүрмийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаж байна. Дүрмэнд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЭММЗ-ийн хурлыг тайлант оны 01.01-ний өдрөөс эхлэн иргэдийг байлцуулахгүйгээр, 100% бичиг баримтанд тулгуурлан хуралдаж, нийт 46 удаа хуралдаж, 1912 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлээд байна, үүнээс 1355 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, жагсаалтын шаардлагад нийцсэн 421 иргэнд өвчний явц, шинжилгээ, үзлэг, өвчтөнд илэрч буй зовиур өөрчлөлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож, биеийн байдал сайжирсан, эдгэрсэн, хяналтын хугацаа дууссан шалтгаанаар 133 иргэний хувь, хугацааг цуцлаад байна.</p> <p>Иргэд, даатгуулагч, ажил олгогчдоос тайлант хугацаанд цахимаар болон цаасаар ирүүлсэн хүсэлтийн дагуу 15161 эмнэлгийн хуудсыг хянаж,</p>		

			<p>хууль тогтоомжийн шаардлага хангахгүй 511 хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж цуцалсан байна.</p> <p>Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан 1 иргэнд сувилалд эмчлүүлэх эрхийн бичиг олгож, сувилалын зардал хүссэн 2 хүсэлтийг хүлээн авч, хянаж баталгаажуулсан.</p> <p>Дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн цахим мэдээллийн сангийн хөтлөлтөнд хяналт тавьж, тайланг 2023 оны жилийн эцсийн болон 2024 оны хагас жилийн тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд гаргаж, газрын даргад танилцуулснаар Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд цаасаар болон цахимаар хүргүүлэв.</p>		
6.7		<p>2024 оныг нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай 2024.04.24 №А/61</p>	<p>Тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлах 38 барилга, оффист үйл ажиллагаа явуулж буй 1057 аж ахуйн нэгжид нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулж бүртгэлгүй ажил олгогчдыг илрүүлэх, хамруулах ажлыг зохион байгуулан, тэмдэглэл үйлдэн, газрын фейсбүүк пэйж хуудсанд нэгдүүлж мэдээ, мэдээлэл авах, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг хийснээр 473 аж ахуйн нэгж, 5521 албан журмын даатгуулагч шинээр хамруулан ажилласан.</p> <p>Нийгмийн даатгалын хамралт нэмэгдүүлэх, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын зөвлөгөө мэдээлэл өгөх, цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Даатгалтай иргэн” арга хэмжээг 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хороонд зохион байгуулан ажилласан. Дээрх ажлын хүрээнд тэтгэвэр тогтоолгох эрх үүсч буй иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, сайн дурын даатгалд</p>		

			хамруулах, гар утасны аппликейшн, цахим үйлчилгээ ашиглах заавар, зөвлөгөө өгөх, ажил олгогчийг шинээр бүртгэх 296 иргэд, даатгуулагчдад зөвлөгөө өгч 600 ширхэг хэвлэмэл материал тарааж ажилласан.		
6.8		Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай 2024.05.02 №А/64	Сүхбаатар дүүргийн Төрийн сангийн хэлтэст шимтгэлийн өртэй төсөвт байгууллагын шаардлагатай тоон мэдээллийг хүргүүлэн хамтарч ажиллаж байна. Нийслэлийн боловсролын газрын шимтгэлийн авлагыг барагдуулахаар Сангийн яаманд албан бичиг хүргүүлсэн. Мөн 45 аж ахуй нэгж нь татан буугдсан, 6 байгууллагын эзэн холбогдогч нас барсан зэргийн тогтоон хувийн хэргийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үйл ажиллагаа зогссон 1.124,1 сая төгрөгийн өртэй 158 аж ахуй нэгж байгууллагыг эрэн сурвалжлуулах шүүхийн шийдвэр гарсан мөн 70 аж ахуй нэгж байгууллагын хаягын тодорхойлолтыг гаргуулж эрэн сурвалжлуулахаар баримт бүрдүүлж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагын жагсаалтыг улирал бүр хүргүүлж ажилласан.		
6.9		“Төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, төсвийн нарийвчилсан хуваарь батлах, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахад баримтлах журам”, “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлал”, “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал	Тус газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны А/72 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлал”, “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөлийг аргачлалын дагуу боловсруулан 2024 оны 06 дугаар сарын 15-ны дотор 2025 оны сангийн төсөв, 2026-2027 оны төсвийн төсөөллийг нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.		

		<p>зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах аргачлал” батлах тухай 2024.05.15 №А/72</p>			
6.10		<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй байгууллагын банкн дах дансны зарлагын гүйлгээг түр зогсоож, шимтгэл, алданги төлүүлэх “Мэдэгдэл”, дансны зарлагын гүйлгээг нээх “Зөвшөөрөл” маягтын загвар батлах тухай 2024.05.21 №А/83</p>	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй байгууллагын банкн дах дансны зарлагын гүйлгээг түр зогсоож, шимтгэл, алданги төлүүлэх “Мэдэгдэл”, дансны зарлагын гүйлгээг нээх “Зөвшөөрөл” маягтын загварыг дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлага үүсгэсэн 1458 аж ахуй нэгж байгууллагын харилцагч банкны дансыг хааж, 316 аж ахуй нэгж байгууллагын 5,845.4 сая төгрөгийн өр, авлагыг үл маргах журмаар данснаас гаргуулан өрийг төлүүлж ажилласан.</p>		
6.11		<p>“Ажлын цаг ашиглалт, бүтээмж, хариуцлагыг сайжруулах” тухай 2024.08.07 №А/139</p>	<p>Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалтыг Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6 дугаар зүйлд “Ажлын цагийн горим, 7 дугаар зүйлд “Амралт, чөлөө, тэтгэмж, тусламж, дэмжлэг үзүүлэх” бүлэг болгон оруулсан бөгөөд журмын хэрэгжилтийг тус газрын цаг бүртгэлийн системээр тогтмол бүртгэж, хүний нөөцийн мэргэжилтэн хяналт тавин ажиллаж байна.</p>		

			<p>Ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтын улирал тохиож байгаатай холбогдуулан төрийн ажлыг тасралтгүй, шуурхай ажлыг үр бүтээлтэй байлгах зарчмын дагуу ажилтны амрах, амралтын хугацаанд түр орлон ажиллах хуваарийг гарган ажиллаж байна.</p> <p>Мөн тус газрын хэлтэс, тасгийн дарга нар болон ажилтан, албан хаагчид ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн дагуу өдөр тутмын ажлыг хийхээс гадна, ажилтан, албан хаагчид “Төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тасгийн дарга нараар батлуулж, гүйцэтгэл, үр дүнг хувьчлан тооцож ажлын бүтээмжийг сайжруулан ажиллаж байна.</p>		
6.12		<p>“Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх” аян зохион байгуулах тухай 2024.09.26 №А/162</p>	<p>Тус аяны хүрээнд газрын төлөвлөгөө гарган батлуулж, шат дараалсан арга хэмжээг авч, хэрэгжүүлэн ажилласан. Үүнд 2041 аж ахуй нэгжийн захирал, нягтлан бодогч нартай өр авлага барагдуулах талаар утсаар холбогдож сануулах, арга хэмжээ авсанаас 4,821.3 сая төгрөгийг бүрэн болон хэсэгчлэн барагдуулсан. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн 12,281.3 сая төгрөгийн өртэй 41 ажил олгогчид Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлснээс 11 аж ахуй нэгжийн 558,7 сая төгрөг бүрэн барагдсан. Банкны төлбөр барагдуулах албатай уулзалт зохион байгуулж албан бичиг хүргүүлэн ажлыг эрчимжүүлж 13 аж ахуй нэгж байгууллагын 189.0 сая төгрөг хэсэгчлэн барагдсан. 2024 онд 6.016,3 сая төгрөгийн өртэй 4 аж ахуй нэгж байгууллагыг шүүхэд өгч шүүхийн шийдвэр гаргуулсан. Үүнээс 216,3 сая төгрөг барагдуулсан. 16 байгууллагын 679,6 сая төгрөгийн өр бүхий байгууллагуудыг эрэн сурвалжлахад материалыг бэлтгэн өгсөн. 5-аас дээш жилийн насжилттай байгууллагуудын мэдээллийг цуглуулж холбогдох ажлыг эрчимжүүлсэн ажилласнаар 9 байгууллагатай уулзалт хийж он дотор барагдуулахаар гэрээ хийсэн бөгөөд 78 сая төгрөгийг</p>		

			<p>барагдуулсан. Мөн 45 аж ахуй нэгж нь татан буугдсан, 6 байгууллагын эзэн холбогдогч нас барсан зэргийн тогтоон хувийн хэргийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үйл ажиллагаа зогссон 1.124,1 сая төгрөгийн өртэй 158 аж ахуй нэгж байгууллагыг эрэн сурвалжлуулах шүүхийн шийдвэр гарсан мөн 70 аж ахуй нэгж байгууллагын хаягын тодорхойлолтыг гаргуулж эрэн сурвалжлуулахаар баримт бүрдүүлж байна.</p>		
6.13		<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн ажил олгогчид харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох тухай “Мэдэгдэл”-ийн загвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах уулзалтын тэмдэглэл”-ийн загвар, “Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах гэрээ”-ний загвар, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хуваарь” маягтын загвар батлах тухай 2024.10.03 №А/169</p>	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн ажил олгогчид харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох тухай “Мэдэгдэл”-ийн загвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах уулзалтын тэмдэглэл”-ийн загвар, “Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах гэрээ”-ний загвар, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хуваарь загварын дагуу хамралт, орлогын хэлтсийн улсын байцаагч нар үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн өр үүсгэсэн аж ахуй нэгж байгууллагын удирдлагатай уулзалт зохион байгуулж 113 аж ахуй нэгжийн 10,080.4 сая төгрөгний шимтгэлийн авлага барагдуулах гэрээ байгуулж, 108 аж ахуй нэгж байгууллагын 3,535.3 сая төгрөгийг барагдуулсан.</p>		

6.14		Улсын байцаагчийн шалгалтад орох албан хаагчдын нэрсийн жагсаалт батлах тухай 2024.11.14 №А/205	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/205 тушаалаар тус газрын нийт 14 ажилтан, албан хаагчид шалгалтад орох эрх үүсэж Улсын байцаагчийн шалгалтад 7 албан хаагч тэнцэж, 2 албан хаагч шалгалтад ороогүй, 5 албан хаагч шалгалтад тэнцээгүй байна.		
6. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол					
7.1		Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай 2023.12.04 №8	НДҮЗ-ийн Нас барсан даатгуулагчийн гэр бүлин гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг мөрдөн ажиллаж 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 644 иргэнд 1,28 тэрбум төгрөг олгосон байна.		
7.2		Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай 2023.12.04 №10	Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай тогтоолыг хэрэгжүүлэн, 1 ор хоногт ногдох төлбөрийн хэмжээг 70,000 төгрөгөөр тооцон 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр тус газраас 13 хүнд 2,0 сая төгрөгийн сувиллын тусламж үйлчилгээний зардал олгосон байна.		
7.3		Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай 2023.12.21 №20	Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж, 1 тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэрийн дансны аргаар тогтоон ажиллаж байна.		